

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хархорин сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2024/18/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Арвайхээр хот 2023 он	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn Аудитор: Э.Энхбаяр Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гандангийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173.
Утас/факс: (976) 7032 3253
Цахим шуудан: ovorkhangai@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Ажлал 03.15 № 195

Тайлбар -ны № -Т

ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.ОДГЭРЭЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Хархорин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хархорин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хархорин сумын ТТЗ-ын 2023 оны төсвийн татварын орлогыг 2,109.7 сая төгрөг, татварын бус орлогыг 412.1 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 3.8 хувь буюу 93.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Харин сумын ТТЗ-ийн төсвийн зарлагын хэмжээг 5,353.9 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 1,016.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

15600118

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

The image shows a circular official stamp of the State Audit Agency of Mongolia. Inside the stamp, there is a signature in blue ink. The stamp is partially obscured by the text 'ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР' on the left and 'О. БАТЖАРГАЛ' on the right.

О. БАТЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,579,831.0	2,897,551.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	17,960,642.7	21,257,911.1
	Нийт хөрөнгийн дүн	20,540,473.7	24,155,462.8
	Нийт өр төлбөрийн дүн	77,781.5	18,863.6
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	20,462,692.2	24,136,599.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	20,540,473.7	24,155,462.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	11,138,230.6	13,924,559.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	8,462,623.4	9,231,110.8
	Үйл ажиллагааны үр дүн	2,675,607.1	4,693,448.8
	Үйл ажиллагааны бус үр дүн	37,566,534.9	1,019,541.8
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(34,886,565.3)	3,673,907.0
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	55,349,257.5	16,282,306.8
	Тайлант оны үр дүн	(34,886,565.3)	3,673,907.0
	Эцсийн үлдэгдэл	20,462,692.2	24,136,599.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	8,568,860.5	10,186,569.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	6,975,125.7	8,046,347.4
	Үйл ажиллагааны ЦМГ	1,593,734.8	2,140,221.6
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(879,214.5)	(1,315,626.6)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(761,112.3)	(273,730.6)
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(46,592.0)	550,864.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,125,659.2	1,079,067.2
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,079,067.2	1,629,931.5
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	4,337,748.2	4,737,380.9
	Урсгал зардал	2,979,096.4	3,424,490.1
	Хөрөнгийн зардал	597,539.6	1,039,160.3
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	4,265,659.9	4,881,274.2
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,568,147.7	2,973,771.5
	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	402,872.0	701,560.7
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	708,542.6	691,551.2
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,448.7	20,285.6
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	573,648.7	494,105.2

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 26.0 сая төгрөгийн 1 зөрчил¹ илэрч, 1 албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт:

1. Эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгөөр 26.0 сая төгрөгийн 2600 боодол өвс, худалдан авсныг нягтлан бодох бүртгэлд бүртгэж, тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2.-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1 "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.6-д "бүх зардал;"- гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгөөр худалдан авсан бараа, материалыг нягтлан бодох бүртгэлд бүртгэж, тайлагнаагүй зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

5.3 Зөвлөмж

Аудитын явцад зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ТТЗ-ийн харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар 4 байгууллага, 3 сангийн тайланг түүвэрт хамруулсан. / ЗДТГ, ИТХ, Энэрэл Хархорин өрхийн эрүүл мэндийн төв, Хархорин Спортын ордон, Эрсдэлээс хамгаалах сан, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан/

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр **432.1** сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 6 албан шаардлага 4 зөвлөмж хүргүүлсэн.

Хархорин сумын Спортын ордон:

- Суутгасан ХХОАТ-ыг зардалд оруулж тайлагнасныг залруулсан
- Хархорин сумын Энэрэл Хархорин өрхийн эрүүл мэндийн төв:
- Тайланд онд 33.0 сая төгрөгийн өр авлагыг тайланд тусгалгүй орхигдуулсныг залруулсан

Хархорин сумын орон нутгийн хөгжлийн сан:

- Ижил төрлийн гүний худаг шинээр гаргах 197.9 сая төгрөгийн 7 ажлыг харьцуулалтын арга ашиглан тус тусад нь худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дэх хэсэгт "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөнийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хархорин сумын Хоршоо хөгжүүлэх сан:

- Шилэн дансны цахим хуудсанд Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөс 263.0 сая төгрөгийг 11 зээлдэгчид хөнгөлөлттэй зээл олгох сумын Засаг даргын 2023 оны А/134 тоот захирамж гарсныг Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр гэсэнд байршуулаагүй зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Хархорин ТТЗ	1	26,000.0	0	0	1	26,000.0	0	0	0	0	0	0
Дүн	1	26,000.0	0	0	1	26,000.0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	1	26,000.0	0	0	0	1	26,000.0	0

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6217143631
ЙЮА0059 9044034